

ЭРДЭНИЙН ЭМИЙН ДЭЭД, РИНСРЭЛИЙН ТУС ЭРДМИЙГ ТОДРУУЛАХ НЬБ.Нандин-Эрдэнэ¹, Б.Гэрэлмаа², Д.Шагдарсүрэн¹, Ш.Болд³^{1,3}ЭЗШУИС, ^{2,3}“Ач” АУИС, ³МАУА**Abstract****IDENTIFYING THE USAGE OF SUPREME PRECIOUS MEDICINE RING SREL**Nandin-Erdene.B¹, Gerelmaa.B², Shagdarsuren.D¹, Bold.Sh³^{1,3}Mongolian University of Pharmaceutical Science^{2,3}“Ach” Medical University³Mongolian Academy of Medical Sciences**Background**

The following ancient medical book currently known to us is relatively detailed about ring srel. Herein: a handwritten sutra by Darma maaramba Luvsanchoidog called “legs bshad be ed’u dkar po’i ‘phreng ba zhes bya ba bzugs so”. However, there is no academic research on the medicinal use of this supreme precious medicine ring srel in Mongolia. Therefore, we have chosen this topic to make it possible to use the written medical scriptures and woodblock books written about ring srel for research and training, especially to explain and interpret the supreme precious medicine in detail.

Purpose

We will study the facts about ring srel in Darma maaramba Luvsanchoidog’s “legs bshad be ed’u dkar po’i ‘phreng ba zhes bya ba bzugs so” manuscript, enrich it with information about ring srel in other ancient medical books, and explain some words.

Conclusion

Supreme precious medicine is a word that means ring srel in Tibetan, a relic in English or whitish, pill-like stuff from cremation residues, and sharil or chandar (cremains) in Mongolian. There are four categories of ring srel: Body ring srel, hair, and nails ring srel, mustard seed-like ring srel and dharma body ring srel. There are five colors of the ring srel: white from bones, red from flesh, blue from yellow water, gold from skin so on. If we distinguish each of its uses, from the medical point of view: Demons and evil spirits, all diseases can not be attacked and not harmed, and from the ritual point of view: it is said that everything you wish to do by keeping it on your body and wearing it on your body will come true.

Keywords: Medical handwritten sutra, supreme precious medicine, ring srel, evil spirits

ҮНДЭСЛЭЛ

Одоогоор бидэнд мэдэгдээд байгаа дараах эмийн сударт ринсрэлийн талаар харьцангуй дэлгэрэнгүй тэмдэглэжээ. Үүнд: Дармо маарамба Лувсанчойдогийн “Сайн номлол цагаан биндэрьяан эрхи” хэмээх оршивой гар бичмэл судар. Уг сударт: 1. Ринсрэл, 2. Биндэрьяа, 3. Бадмаараг, 4. Индранил, 5. Маргад, 6. Алмаз, 7. Шүр, 8. Сувд, 9. Алт, 10. Мөнгө, 11. Лавай гэж дараалуулан хамгийн эхэнд ринсрэлийн талаар дурдсан байна [1].

Эмийн судраас гадна Сажа бандида Гунгаажалцан (1182-1251)-гийн sDom gsum rab dbye хэмээх сударт:

Ринсрэлийн зарим нь адаас бүтсэн,

Зарим нь дөрвөн махбодын хүчнээс бүтсэн нь буй.

Шашинд баясдаг зарим тэнгэрүүд ч

Сүжиг төрүүлэхийн тухайд хувилгасан нь ч буй хэмээн тэмдэглэжээ [2]. Сажа бандида энэ судартаа хуурамч ринсрэл ч бас байдгийг онцгой анхаарах талаар нарийвчлан дурдсан нь практикийн болон шинжлэх ухааны их ач холбогдолтой юм.

Ринсрэлийн тус эрдмийн талаар дээд хийгээд эгэл хоёр зүйл буй. Эрхэм болсон нь ялгуулсан хийгээд, шарваа, бодисадва, югүзэрийн пэлдэн, ринсрэлийг тахих, хадгалах шүтээнээр адыг сахих бөгөөд дэв бузар, өвчнийг арилган, өмнөх төрлөө дурсан, тэнгэр

бурхдаас илүү чөлөө учирлын ариун үрийг олно хэмээсэн байдаг. Энэ мэт ринсрэлийн талаар дурдсан судар номууд багагүй байна. Нөгөө талаар, зөвхөн Гандантэгчэлин хийдэд 2022 оны 6 дугаар сарын 24-26-нд Бурхан багшийн их эрдэнийн ринсрэлийг буцаан залсантай холбоотой эерэг, сөрөг олон мэдээнүүдийг эс тооцвол ринсрэлийн анагаах ухааны чиглэлийн судалгаа манай улсад хийгдээгүй байна.

Тиймээс бид ринсрэлийн тухай бичсэн анагаах ухааны бичмэл судар, барын номыг судалгаа, сургалтад ашиглах боломжийг бүрдүүлэх, ялангуяа дээд эрдэнэ ринсрэлийн тус бүрийг нарийвчлан тайлбарлах, тайлал хийхээр энэхүү сэдвийг сонгон авлаа.

ЗОРИЛГО

дармо маарамба Лувсанчойдогийн «Сайн номлол цагаан биндэрьяан эрхи хэмээх оршивой» гар бичмэл сударт буй ринсрэлийн талаарх баримтыг бусад судар дахь ринсрэлийн мэдээллээр баяжуулан зарим үгийн тайлбарыг хийх.

СУДАЛГААНЫ АРГА

1. Герменевтик арга

Герменевтик арга нь нь судалж буй зүйлийнхээ учир зүйг учир шалтгааны холбоогоор тайлбарлан судалдаг. Гол мөн чанар нь зохиогчийг өөрөөс нь илүү ойлгож болох буюу зохиогчийн ухамсарлаж бодоогүй гол зорилт болон далд нуугдмал утга санааг илрүүлэх явдал юм. Иймээс энэхүү аргаар судалж буй асуудал тухайлбал ринсрэл, түүнтэй холбоотой зарим нэр томъёоны үгийн гарал үүсэл, далд утга, давхар санаа, агуулгыг судлан тогтоох зэрэгт ашигласан.

2. Магадлан жагсаах арга

Сурвалж бичгийн доторх ринсрэлтэй холбоотой мэдээллийг төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгүүдийг бүрдүүлэхэд энэхүү аргыг хэрэглэв.

ҮР ДҮН БА ХЭЛЦЭМЖ

Ринсрэлийн тухай өгүүлсэн судар номууд

Бидэнд олдоод байгаа баримтаас үзэхэд ринсрэлийн тухай гуравдугаар дүрийн Гармава Ранжундорж (1284-1339)-ийн “Эмийн нэрсийн далай” номонд нилээд тодорхой бөгөөд товч дурджээ. Дараа нь анагаах ухааны бус sDom gsum rab dbye хэмээх номондоо алдарт “Субашид”-ыг бичсэн Сажа бандида Гунгаажалцан (1182-1251) рэнсэлийг хэрхэн танихын тухайтад болон сүсэгтэн олныг төөрүүлэх гэж хийсэн нь олон байдаг тухай дурдсан байна.

Дармо маарамба Лувсанчойдог (1638-1710)-ийн «Сайн номлол цагаан биндэрьяан эрхи хэмээх оршивой» сударт:

1. Лагшин шарилын ринсрэл,
2. Лагшин унгарилын ринсрэл,
3. Гичийн үр мэт ринсрэл,
4. Номын лагшны ринсрэл хэмээн ялгаж бичсэн байна.

1. Лагшин шарилын ринсрэл нь шарам хэмээх дуунаас эвдлэн сүйтгэхүйгээс хагацсан бат бэх хатуу очир лагшны шарилыг найман хувьд хуваасны нэгэн болох буй. Нэрийтгэлийн мах ясны өчүүхэн хувь төдийд ч орох нь буй бөлгөө. Лагшны шарилын найман хувийн домог нь бусдад тодорхой ба Мажэйда (Ajātasattu) хааны хувьд бурхны лагшны шарил нь Төвөдөд буй бөгөөд тахианы өндөг төдий хэмжээтэй хэмээн алдаршив.

2. Лагшин унгарилын ринсрэл нь тэргүүний үснэр хийгээд хумс тэргүүтнийг хэлнэ.

3. Гичийн үр мэт нь өнөө маргаашийн ринсрэл хэмээн алдаршсан бөлгөө. Том нь тахианы өндөг төдий ба дунд хэмжээтэй нь хятад буурцаг төдий, өчүүхэн нь цагаан гич төдий бөгөөд алин ч зохистой гарсан болой.

4. Ялгуулсны ринсрэл буюу Номын лагшны ринсрэл нь эрдэнийн дээд юм.

Ер санасан хэрэг бүхнийг гарган үйлдэгч Шарвааг (сонсогч), брадэгбуд (биелүүлэгч, сонсогч, махаянагийн шүтэн бишрэгч), бодисадвагийн

Сайх тэр нь төгс егзэр (тарнийн номд


мэргэшсэн хутагт)-ийн шарил

Сайтар тахин биедээ зүүсэн төдийхнөөр

Санасан хэрэг бүхэнд гэмгүйн чадалтан

хэмээн зарлигласан болой.

Зэндмэнийн эрхтийн хаан буюу “Биндэрьяан дээд сайн оюут хэмээн өргөн дэлгэр номложээ.



“Сайн номлол цагаан биндэрьяан эрхи хэмээх оршивой” гар бичмэл судар

Дэумар гэвш Данзанпунцаг (1672-1739)-ийн “Эмийн шилэн бөмбөг” номонд: Бүтээлч буянтны шарилын эрдэнийг тахиж, биедээ хадгалж үйлдвээс өвчний ад дон бүхэн халдаж үл чадна хэмээжээ [5].

Дээрх дөрвөн эрдэмтнээс гадна “Нэрийтгэлээс гэтэлснийг үзүүлсэн ганц хөвгүүний нууцын тайлбар” хэмээх сударт:

Яснаас цагаан ринсрэл,

Махнаас улаан,

Шар уснаас хөх,

Арьснаас алтан өнгөт шарам буурцаг төдий,

Зүрхэнд таван өнгө гарах болой хэмээсэн байна.

Энэхүү баримт нь ринсрэл ихэнхдээ цагаан, улаан, хөх, алтлаг зэрэг өнгөтэй, хэмжээний хувьд янз бүр байдгийг тодорхойлсон байна. Бид судалгааны явцад Гандантэгчэнлин хийдийн их гэсгүй багштаны лагшинг хайлуулснаас гарсан олон өнгийн ринсрэлийг үзэх хувь олдсон.



Гандантэгчэнлин хийдийн их гэсгүй Багшийн ариун лагшингаас гарсан ринсрэл

Их гэсгүй багштан 2019 он, гахай жилийн зуны дунд сарын хуучдын 17-нд ертөнцийн мөнх бусыг үзүүлж, дүрст лагшингаа номын агаарт хураасан. Багштаны лагшин шүтээнийг хайлахад их эрдэнийн үрэл, ринсрэл тэргүүтэн олон гарсан.

Үгийн тайлбар, тус эрдмийг тодруулсан нь

Ринсрэлийг төвөдөөр ᠠᠨᠭᠤᠯᠠᠭ англиар relic (whitish, pill-like stuff from cremation residues-чандарлах үлдэгдлээс үүссэн цайрсан, эм шиг зүйл), монголоор шарил, чандар, санскритаар śaṅga, манжаар ᠰᠡᠯᠢ хятадаар 舍利 – sheli гэж нэрлэдэг. Заримдаа mchog gi nor bu - дээд эрдэнэ, nang gi nor bu – дотоод эрдэнэ гэж тэмдэглэсэн байна.

Ринсрэлийн гол тус эрдэм нь дэв бузар, цөв шүглэснийг ариутган цэвэрлэнэ. Ялангуяа тачаангуйн дэв (хуял тачаал), муу санааны

дэв (шунал, атга санаа), хилэнгийн дэв (уурын мунхаг), нөхцсөн дэв (бузартах)-ийг угаах адил арилгана. Эрхэм болсон нь ялгуулсан хийгээд, шарваа, бодисадва, югзэрийн пэлдэн ('phel gdung), ринсрэлийг тахиx, хадгалах шүтээнээр адыг сахих бөгөөд дэв бузар, өвчнийг арилган, өмнөх төрлөө дурсан, тэнгэр бурхдаас илүү чөлөө учирлын ариун үрийг олно гэж онцлон тэмдэглэжээ.

Гуравдугаар дүрийн Гармава Ранжүндоржийн “Эмийннэрсийндалай”, Дармо маарамба Лувсанчойдоггийн «Сайн номлол цагаан биндэрьяан эрхи хэмээх оршивой» судар, Дэүмар гэвш Данзанпунцагийн Сажа бандида Гунгаажалцан нарын бүтээлд буй ринсрэлийн тодорхойлолт, хэрэглээг дараах хүснэгтээр ангилан товч гаргав (Хүснэгт 1) [6,7,8,9].

Хүснэгт 1. Судалгаанд авсан гол судар, номонд дурдсан ринсрэлийн хэрэглээ

Судар номын нэр			
Лувсанчойдог (1638-1710)-ийн «Сайн номлол цагаан биндэрьяан эрхи хэмээх оршивой» судар	Ранжүндорж (1284-1339)-ийн “Эмийн нэрсийн далай” ном	Данзанпунцаг (1672-1739)-ийн “Эмийн шилэн бөмбөг” ном	Гунгаажалцан (1182-1251)-ийн sDom gsum rab dbye ном
Ринсрэлийн талаар бичсэн баримт			
Ринсрэлийн тухай маш дэлгэрэнгүй бичсэн. Үүнд - Лагшин шарилын ринсрэл - Лагшин унгарилын ринсрэл - Гичийн үр мэт ринсрэл - Номын лагшны ринсрэл Эрхэм гол нь зэндмэнэ эрдэнийн хаан бөгөөд эрдэнэ биндэрьяагийн дээд хэмээн номлосон буй. Сайтар тахин биедээ зүүсэн төдийхнөөр санасан хэрэг бүхэнд гэмгүйн чадалтан хэмээсэн.	Ялгуулсны ринсрэл нь эрднийн эмийн дээд болох бөгөөд хүссэн бүхнийг хангана. Өөрөө ялагч, бодисадва, егүзэр нарын шарилыг тахиx буюу биедээ хадгалваас ад чөтгөр бүхэнд хорлогдохгүй.	Тачаангуйн дэв, муу санааны дэв, хилэнгийн дэв ба нөхцөх дэвийг угаах мэт арилгана. Бүтээлч буянтны шарилын эрдэнийг тахиж, биедээ хадгалж үйлдвээс өвчний ад дон бүхэн халдаж үл чадна.	Ринсрэлийн зарим нь адаас бүтсэн, зарим нь дөрвөн махбодын хүчнээс бүтсэн нь буй. Шашинд баясдаг зарим тэнгэрүүд ч сүжиг төрүүлэхийн тухайд хувилгасан нь ч буй. Өнөө цагт ринсрэлийн ихэнх нь хуурамчаар үйлдсэн ринсрэл мөн гэжээ.

Хэрэглээний төстэй байдал

1. Гуравдугаар дүрийн Гармава Ранжундоржийн “Эмийн нэрсийн далай” номонд: Өөрөө ялагч, бодисадва, егүзэр нарын шарилыг тахиx буюу биедээ хадгалваас ад чөтгөр бүхэнд хорлогдохгүй.

2. Дармо маарамба Лувсанчойдогийн “Сайн номлол цагаан биндэрьяан эрхи хэмээх оршивой” судар: Сайтар тахин биедээ зүүсэн төдийхнөөр санасан хэрэг бүхэнд гэмгүйн чадалтан болно.

3. Дэүмар гэвш Данзанпунцагийн “Эмийн шилэн бөмбөг” номонд: Бүтээлч буянтны шарилын эрдэнийг тахиж биедээ хадгалж үйлдвээс өвчний ад дон бүхэн халдаж үл чадна.

Ерөнхийд нь нэгтгэвэл өөрөө ялагч, бодисадва, егүзэр нарын шарилыг тахиx буюу биедээ хадгалваас ад чөтгөр бүхэнд хорлогдохгүй, тахиx, биедээ зүүсэн төдийхнөөр санасан хэрэг бүхэн гэмгүй бүтэх, өвчний ад дон бүхэн халдаж үл чадна гэсэн утга гарна.

Ринсрэл бол агуу багш нарыг тэнгэрт хальсны дараа хайлуулахад гарах үнс нурам, бурхан багшийн хөшөө, суварга зэрэг ариун дагшин газруудаас бий болдог дээд эрдэнэ, дурсгал юм. Мөн үнс, ясны хэсгүүдийг цуглуулж, хэсэг хугацаанд хадгалсны дараа ринсрэл үүсэх тохиолдол ч байдаг. Хэн нэгэн хүн ринсрэлийг үнэнчээр хадгалж, тахин шүтэж чадвал хэсэг хугацааны дараа үржиж олширдог. Өөрөөр хэлбэл томорч, хажуу талдаа овойлт гарч, дараа нь уг овойлт нь жижиг ринсрэл болдог. Үүнийг энэрэнгүй сэтгэл хийгээд билиг ухааны эрдмийг олсноор үүсэн буй болдог хэмээжээ.

ДҮГНЭЛТ

Ринсрэл нь төвөдөөр ring srel, англиар relic буюу чандарлах үлдэгдлээс үүссэн цайрсан, эм шиг зүйл, монголоор шарил, чандар гэсэн утгатай үг юм. Ринсрэлийг лагшин шарилын ринсрэл, лагшин унгарилын ринсрэл, гичийн үр мэт ринсрэл, номын лагшны ринсрэл

гэж дөрөв ангилна. Яснаас цагаан ринсрэл, махнаас улаан, шар уснаас хөх, арьснаас алтан өнгөт зэрэг таван өнгө гардаг ажээ. Хэрэглээг нь тус бүрт нь ялгавал анагаах ухааны талаас: өвчний ад дон бүхэн халдаж үл чадна, ад донд хорлогдохгүй, зан үйл талаасаа: биедээ хадгалсан, биедээ зүүсэн төдийхнөөр санасан хэрэг бүхэн гэмгүй бүтнэ хэмээсэн байна.

НОМ ЗҮЙ

1. Дармо маарамба Лувсанчойдогийн “Сайн номлол цагаан биндэрьяан эрхи”. Төвөд толгойгүй шар бичгийн ном. Төвөд хэлнээс орчуулсан Чимэг (гар бичмэл) редактор Ш.Болд, 2020

2. Сажа бандида Гунгаажалцан. sDom gsum rab dbye. dra 'jug pa/ ser byes rig mdzod chen mo, 2022

3. Гавидорж. 'khrungs dpe dri med shel gyi mi long. Ардын хэвлэлийн хороо. 1995, х.14-15

4. Дармо маарамба Лувсанчойдогийн “Сайн номлол цагаан биндэрьяан эрхи”. Төвөд толгойгүй шар бичгийн ном. Төвөд хэлнээс орчуулсан Чимэг (гар бичмэл), редактор Ш.Болд, 2020

5. Дэүмар гэвш Данзанпунцагийн “Эмийн шилэн бөмбөг, эрхэс”. 1980. (Хувийн цуглуулга)

6. Ранжундоржийн “Эмийн нэрсийн далай”. g.Yu thog yon tan mgon po sogs. sngo 'bum sman gyi gter mdzod. Kan su'u Mi rigs dpe sgrun gang. 2006

Уншин танилцаж,
нийтлэх санал өгсөн:
ЭЗУ-ы доктор,
профессор Л.Уламбаяр